



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Өвөрхангай аймгийн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн



**Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан хэдий ч ,
үйл ажиллагаа төдийлөн үр нөлөөтэй хэрэгжээгүй байна**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)</p> <p>Аудитын менежер (Д.Гансүх)</p> <p>Ахлах аудитор (Ж.Нямаа)</p> <p>Аудитор (П.Норпил)</p> <p>2018 оны 10 дугаар сар</p> <p>Уг тайланг www.audit.mn, https://www.facebook.com/uvur.khangai.audit facebook хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас,70323253 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 405 тоот)</p>	<p>Товчилсон үгийн тайлбар3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5</p> <p>Бүлэг 1: Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна.5-7</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон. • Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна. • Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага байна. • Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах зайлшгүй бодит хэрэгцээ шаардлага байхгүй байна. • Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна. • Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаагүй байна. <p>Бүлэг 2: Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн хангалттай хэрэгжээгүй байна.....7-16</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, түргэн шуурхай гүйцэтгэж байгаа ч хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, алдаатай хасах залруулгын гүйлгээ, орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу, амлалтын бүртгэл хөтлөөгүй байгаа нь үнэн зөв байдал төдийлөн хангагдахгүй байна. • Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага журмын дагуу хэрэгжиж байна. • Төсвийн хэрэгжилтийг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа ч нэмэлт санхүүжилтийн эрхийг журмын дагуу хяналт тавьж олгоогүй байна. • Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан. • Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан. • Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна. • Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт бүрэн хэрэгжээгүй байна.. <p>Дүгнэлт.....16-17</p> <p>Зөвлөмж.....17-18</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....18-19</p> <p>Хавсралтууд</p>
---	---

Ерөнхий зүйл***Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:***

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд САГ-2018-03-СА төлөвлөгөөг үндэслэн Өвөрхангай аймагт Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд 2017 оныг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Төгрөг, Уянга, Богд, Баруубаян-улаан, Баянгол сумдын төрийн сан, аймгийн төрийн санд харьяалагддаг байгууллагуудыг хамруулан тэдгээрийн эрх зүйн үндэслэл, 2017 оны төрийн сангийн мемориалын баримт, ЗЭБ-ны маягтууд, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, нэмэлт санхүүжилтийн материал, хувийн хэргийн материалуудад үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитын Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гарсан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга авах, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтот арга хэмжээнээс түүвэрлэн горим сорил хийж гүйцэтгэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Засгийн газрын тогтоол

дүн

- ✓ Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай-2013
- ✓ Санхүүгийн алба байгуулах тухай-2014
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааны журам-2015

Сангийн сайдын тушаал

- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх , төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам-2013
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам- 2014
- ✓ Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам-2014
- ✓ Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар-2015
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам-2016
- ✓ Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам болон бусад холбогдох хууль журмууд

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ: Үндэсний аудитын газрын Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан САГ-2018-03-СА аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав. Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын ахлах аудитор Ж.Нямаа, аудитор П.Норпил, нягтлан бодогч Р.Цэрэндолгор нар 2018 оны 09 дүгээр сарын 09-өөс 11 дугаар сарын 04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан хэдий ч , үйл ажиллагаа төдийлөн үр нөлөөтэй хэрэгжээгүй байна .

БҮЛЭГ-А

Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна.

А.1 Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоо зөв оновчтой байна.**А.1.1 Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон.**

Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжихгүй хууль тогтоомжийн заалтууд бий юу? гэсэн санал асуулгад 11 сумын төрийн санг хамруулан санал асуулгын дүнг нэгтгэлээ. Нэгтгэсэн дүнгээр хамрагдсан бүх төрийн сангууд "үгүй" гэсэн хариулт өгснөөс үзэхэд төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжихгүй хууль тогтоомжийн заалтууд байхгүй байна.

А.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна.

Төрийн сангийн үйл ажиллагаанд хоорондоо уялдахгүй байгаа болон зөрчилтэй хууль тогтоомжийн заалтууд бий юу? гэсэн санал асуулгад шалгалтад хамрагдсан 11 сумын төрийн сангаас санал асуулга авч дүнг нэгтгэсэн. Нэгтгэсэн дүнгээс үзэхэд 11 сумын төрийн сан "үгүй" гэсэн хариулт өгсөн нь төрийн сангийн үйл ажиллагаанд хоорондоо уялдахгүй байгаа болон зөрчилтэй хууль тогтоомжийн заалтууд байхгүй байна.

дүн**А.2 Төрийн сангийн тогтолцоо бодлого чиг үүрэгтэйгээ нийцэж байна.****А.2.1.Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага гарсан байна.**

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн актуудад шинэчлэх сайжруулах шаардлагатай заалт байна уу? Тийм бол саналаа бичнэ үү гэсэн асуултад аймгийн төрийн сангаас дараах саналыг өгсөн байна.

СС-ын 2013 оны 73-р тушаалын 2-р хавсралтаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай" журмыг шинэчлэн өөрчлөхөөр төсөл боловсруулагдаж байгаа. Тус журмын 1-р хавсралтаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам" хүчингүй болсон байна. Мөн СС-ын 2014 оны №55 тушаалаар батлагдсан 6-р хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг шинэчлэх шаардлагатай байна гэсэн саналыг аймгийн төрийн сан өгсөн бол бусад 10 сумдын төрийн сангаас "үгүй" гэсэн санал өгсөн байна.

А.2.2.Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлага байхгүй байна.

Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага байна уу? гэсэн санал асуулгад Бат-өлзий сумаас бусад 10 сумдын төрийн сан "үгүй" гэсэн хариулт өгсөн. Үүнээс үзэхэд төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага байхгүй байна.

Ямар чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлагатай талаар санал авахад дараах сумуудаас санал ирүүлсэн байна. Үүнд:

- Хархорин сумын төрийн сангаас: Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйлгээ арилжааны банкаар хийгдэж байгааг төрийн сангаар хийлгэх саналыг өгсөн.
- Бат-өлзий сумын төрийн сангаас: Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай, Төрийн сан дээр худалдан авах ажиллагаа, статистикийн ажил давхар хариуцаж байна. Ү-7 программ нь ажиллагаа ихтэй учир дутагдалтай программ байна.
- Нарийнтээл сумын төрийн сангаас: төрийн сангийн сүлжээг шилэн кабелд холбож өгөх саналтай байна.
- Төгрөг сумын төрийн сангаас Төрийн сангийн системийн ачааллын асуудлыг зохицуулах, төрийн сангийн хуулга, үлдэгдэл үнэн бодитой гарахгүй байгааг засах гэсэн саналууд ирсэн.

А.3 Төрийн сан хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий болгосон.**А.3.1.Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна.**

Таны хэрэгжүүлж буй чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна уу? гэсэн санал асуулгад Хархорин, Бат-өлзий сумын төрийн сан ажлын ачаалал ихтэй гэсэн тайлбараар "үгүй" гэсэн хариулт өгсөн бол бусад 9 сумын төрийн сан "тийм" гэсэн хариулт өгснөөс үзэхэд хэрэгжүүлж буй чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна

Уянга сумын Санхүүгийн албаны дарга буюу сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч нь 2017 онд 3 удаа, төрийн сангийн мэргэжилтэн нь 2 удаа солигдсон. Уянга сумын Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны Б/11 тоот захирамжаар төрийн сангийн мэргэжилтний ажлыг Түр орлон гүйцэтгэгчээр Б.Энхбатыг томилсон боловч одоогоор ерөнхий нягтлан бодогчийн болон төрийн сангийн мэргэжилтний ажлыг нэг хүн хийж байна.

дүн

Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийг өөр ажилд шилжүүлсэн, төрийн сангийн мэргэжилтэн нь өвчний улмаас ажлаас чөлөөлөгдсөнөөс шалтгаалж Санхүүгийн албаны чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, ажил үүргийн давхардал, ажлын ачаалал үүсэж, дотоод хяналт алдагдан үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн байна. Иймд Уянга сумын Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттойгоо нийцээгүй байна.

А.3.2.Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаагүй байна.

Танай хэлтсийн хэрэгжүүлж буй чиг үүрэг бусад газар, хэлтсийн ажлын чиг үүрэгтэй давхардаж байна уу? гэсэн санал асуулгад Бат-өлзий сумын төрийн сан худалдан авах ажиллагааны ажлын чиг үүрэг давхардаж байгаа гэсэн санал өгсөн бол 10 сумын төрийн сан "үгүй" гэсэн хариулт өгснөөс үзэхэд хэлтсийн хэрэгжүүлж буй чиг үүрэг бусад газар, хэлтсийн ажлын чиг үүрэгтэй давхардаагүй байна.

А.4 Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого стратеги байна уу гэсэн энэ асуудал нь орон нутагт хамааралгүй байна.

А.4.1.Сангийн яам дунд хугацааны стратегийн төлөвлөгөөндөө Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого тусгасан байна уу гэсэн асуудал нь орон нутагт хамааралгүй байна.

Энэ асуудал нь орон нутагт хамааралгүй байна.

А.4.2.Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, биелэлтийг үнэлсэн байна.

Төрийн сангуудын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж "дунд" гэсэн үнэлгээ өгсөн байна.

БҮЛЭГ-Б

Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн хангалттай хэрэгжээгүй байна.

Б.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу төдийлөн үр нөлөөтэй гүйцэтгээгүй байна.

Б.1.1. Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, түргэн шуурхай гүйцэтгэж байгаа ч хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, алдаатай хасах залруулгын гүйлгээ, орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу, амлалтын бүртгэл хөтлөөгүй байгаа нь үнэн зөв байдал бүрэн хангагдахгүй байна.

МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны 8.4 дэх заалтын дагуу Төрийн сан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийн дагуу батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны 8.5 дахь заалтын дагуу хөрөнгө оруулалтын зардлыг гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд шилжүүлсэн байна.

дүн

Шалгалтад 11 төрийн сангийн 110 байгууллагын 207 дансны 500.0 мянган төгрөгөөс дээших 19558 гүйлгээг мемориалын болон анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд шаардлага хангахгүй 204 гүйлгээ байна.

Аймгийн төрийн сан, Хужирт, Бат-Өлзий сумын төрийн сангууд журмын 7.5, 7.6, 7.7 дахь заалтын дагуу хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн байна.

Дээрх шаардлага хангахгүй 204 гүйлгээнээс 102 гүйлгээ хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, 4 гүйлгээ төлбөрийн болон анхан шатны дэмжих баримт нь төрийн сангийн тэмдэглэгээтэй тохирохгүй байгаа, 41 орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу хийгдсэн, 55 гүйлгээ залруулсан боловч төлбөрийн хүсэлт хавсаргаагүй, 2 гүйлгээ төлбөрийн хүсэлт бичигдсэн өдрөөс хойш ажлын 4-7 хоногийн дараа хийгдсэн байна.

Арвайхээр сумын төрийн сангийн 6, Уянга сумын төрийн сангийн 65, Хархорин сумын төрийн сангийн 14, Баруунбаян-Улаан сумын төрийн сангийн 5, Богд сумын төрийн сангийн 7, Төгрөг сумын төрийн сангийн 5, бүгд 102 гүйлгээг дарга, нягтлан бодогчийн гарын үсэг дутуу шаардлага хангахгүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийж хянасан нь МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.5 дахь заалтыг зөрчсөн байна¹. Тухайлбал:

- Арвайхээр сумын төрийн санд бүртгэлтэй 21 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 3358 гүйлгээг түүвэрлэн үзэхэд ЕБ-ийн 1-р сургуулийн 6593.7 мянган төгрөгийн 2, 1-р цэцэрлэгийн 3584.5 мянган төгрөгийн 2, 9-р цэцэрлэгийн 10316.4 мянган төгрөгийн 2, нийт 20494.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй, тамгагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.
- Уянга сумын төрийн санд бүртгэлтэй 11 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 1354 гүйлгээг түүвэрлэн үзэхэд ЗДТГ-ын 3978.2 мянган төгрөгийн 3, ЕБ-ийн 2-р сургуулийн 85044.5 мянган төгрөгийн 12, Жаргалант багийн сургуулийн 31380.5 мянган төгрөгийн 15, Жаргалант багийн Цэцэрлэгийн 14083.9 мянган төгрөгийн 11, Жаргалант багийн эмнэлгийн 9542.8 мянган төгрөгийн 8, Соёл хөгжлийн төвийн 3602.9 мянган төгрөгийн 2, эмнэлгийн 9188.9 мянган төгрөгийн 6, ОНХСангийн 1600.0 мянган төгрөгийн 1 гүйлгээнүүд нягтлан бодогчийн гарын үсэггүй, ЕБ-ийн 1-р сургуулийн 6174.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ захирлын гарын үсэггүй, ИТХурлын 4025.9 мянган төгрөгийн 3, Цэцэрлэгийн 4881.7 мянган төгрөгийн 2 гүйлгээ дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй, тамгагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.
- Хархорин сумын төрийн санд бүртгэлтэй 16 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 3021 гүйлгээг түүвэрлэн үзэхэд Хархорин сумын ЗДТГ-ын 550.0 мянган төгрөгийн 1, Хорих 426 -р ангийн 800.0 мянган төгрөгийн 1, 5-р цэцэрлэгийн 806.5 мянган төгрөгийн 1, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн 530.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ нягтлан бодогчийн гарын үсэггүй, Хархорин сумын СХТ-ийн 5238.1 мянган төгрөгийн 10 гүйлгээ байгууллагын даргын гарын үсэггүй төлбөрийн шилжүүлгээр гүйлгээ хийгдсэн.
- Баруунбаян-Улаан сумын төрийн санд бүртгэлтэй 6 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 686 гүйлгээг түүвэрлэн үзэхэд ЗДТГ-ын 5273.3 мянган төгрөгийн 3, ЕБС-ийн 11180.8 мянган төгрөгийн 1, Соёл хөгжлийн төвийн 1000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй, тамгагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.

¹ МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.5 дахь заалт "Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтад заасан ТТ-1, ТТ-2 маягтын дагуу 2 хувь үйлдэн харьяалагдах төрийн санд хүргүүлнэ"

дүн

- Богд сумын төрийн санд бүртгэлтэй 6 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 743 гүйлгээг түүвэрлэн үзэхэд ЕБС-ийн 701.6 мянган төгрөгийн 1, ОНХС-ийн 36191.4 мянган төгрөгийн 6 гүйлгээнүүд дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.
- Төгрөг сумын төрийн санд бүртгэлтэй 6 төсвийн байгууллагын 500.0 мянган төгрөгөөс дээших дүнтэй 721 гүйлгээг түүвэрлэн үзэхэд ЕБС-ийн 1432.9 мянган төгрөгийн 3,Эмнэлгийн 1498.4 мянган төгрөгийн 2 гүйлгээнүүд дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй, тамгагүй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.

Уянга суманд хамгийн олон гүйлгээ шаардлага хангахгүй баримтаар гүйлгээ хийгдсэн байгаа нь ерөнхий нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтнүүд олон удаа солигдож өөрчлөлт орсноос шалтгаалсан. Хархорин, Арвайхээр суманд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 2017 онд дотоод хяналт хийгдэж зөвлөмж өгөгдсөн боловч дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, бусад сумдын хувьд дотоод хяналт хийгдээгүй байна.

Нийт түүвэрт хамрагдсан 19558 гүйлгээнээс 102 гүйлгээ шаардлага хангахгүй байгаа нь тооны хувьд бага дүнтэй байгаа ч Төрийн сангийн банк гэдэг утгаараа чанарын хувьд зөрчилтэй асуудал байна. Төсвийн байгууллагын батлагдсан санхүүжилтээс илүү мөнгө шилжүүлэх ЗЭБ, сарын хуваарьт хяналт тавиагүй байх үр нөлөөг үүсгэж байна.

Аймгийн төрийн сан харьяа байгууллагуудынхаа буруу шивсэн баталгаажуулах зарлагын 55 гүйлгээг залруулахдаа мемериал ордер бичиж гүйлгээ хийсэн ч төлбөрийн хүсэлт хавсаргаагүй баталгаажуулаагүй нь МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.14 дэх заалтыг зөрчсөн.²

Төсвийн тухай хууль 37.1.2, МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тухайн үед нь ИТХ-ын тогтоол шийдвэр нь гарч зориулалтын дагуу зарцуулагдсан ч анхан шатны баримтыг үдэж цэгцлээгүйгээс шалтгаалж ОНХО-оос Сант сумын ЗДТГ-т 2017.11.30-нд шилжүүлсэн машины үнэ 30000.0 мянган төгрөг, Өвөрхангай аймгийн Засаг дарга данснаас Баянгол сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтэд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зориулалттай зардалд 2017 оны 11 сард шилжүүлсэн 12900.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ шилжүүлэг байхгүй, ОНХО-ын данснаас 2017 оны 06 сарын 02-нд Арвайхээр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтэд шилжсэн 290 жилийн ойн арга хэмжээний зардал 20000.0 мянган төгрөг, Өнө монгол гэр ХХК-нд 2017 оны 06 сарын 30, 07 сарын 26-нд шилжүүлсэн гэрийн үнэ 5000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ шилжүүлэг, дэмжих баримт нь өдрийн гүйлгээний мемориалын баримтад байхгүй байна.

Өвөрхангай аймгийн Засаг дарга данснаас аймгийн ЗДТГ-т 2017 оны 2 дугаар сарын 24-нд шилжүүлсэн гадаад арга хэмжээний зардал 2000.0 мянган төгрөгийн гүйлгээ, Мэргэд сургуулийн 2017 оны 03 сарын 07-ны Нийгмийн даатгалын төлбөр болох 1000.0 мянган төгрөгийн залруулгын гүйлгээг тус тус ажлын 4-7 хоногийн дараа хийсэн нь МУЗГ-ын 2015 оны 24-р тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.2, 8.10 дахь ³ н заалтыг зөрчсөн.

² МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.14 " Төрийн сан төсвийн байгууллагын ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг системд бүртгэхдээ нэр, данс, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллыг буруу шивсэн баталгаажуулаагүй зарлагын гүйлгээг залруулах тохиолдолд энэхүү журмын 7-р хавсралтад заасан ТТ-7 маягтыг үйлдэн тухайн байгууллагын үндсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг хавсаргаж 1-р гарын үсгийг Төрийн сангийн хэлтэс, албаны дарга, 2 дугаар гарын үсгийг гүйлгээ хариуцсан мэргэжилтэн нар зурж баталгаажуулан залруулна"

³ МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.12 дугаар заалт- "Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 хоногийн дотор Төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана"

дүн*Орлого бууруулах гүйлгээний хувьд*

Орлого бууруулах 2330 гүйлгээг түүвэрлэн үзэхэд Уянга, Хархорин, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Богд, Төгрөг, Баянгол сумдын төсвийн байгууллагуудын 41 орлого бууруулах гүйлгээ орлогын хуулга хавсрагдаагүй, анхан шатны баримтыг бүрэн бүрдээгүй байхад залруулах бичилт хийсэн байгаа нь МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.12 дахь заалтыг зөрчсөн.

Тухайлбал:

- Уянга сумын ЗДТГ, 1,2-р сургууль, СХТ, Эмнэлгийн нийт 9553.6 мянган төгрөгийн 7 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй, нягтлан бодогчийн гарын үсэг дутуу төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн.
- Хархорин сумын 3,1-р сургууль, Нэгдсэн эмнэлгийн 5819.1 мянган төгрөгийн 6 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй.
- Бат-Өлзий сумын ЗДТГ-ын 2017 оны 08 сарын 31-нд хийгдсэн 241.1 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээ орлогын хуулгагүй байна.
- Баруунбаян-Улаан сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, Эмнэлгийн нийт 41816.4 мянган төгрөгийн 17 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй гүйлгээ хийгдсэн.
- Богд сумын ЕБС, ЗДТГ-ийн нийт 8165.1 мянган төгрөгийн 7 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй гүйлгээ хийгдсэн.
- Төгрөг сумын ЕБС, Эмнэлгийн нийт 1746.3 мянган төгрөгийн 2 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй гүйлгээ хийгдсэн.
- Баянгол сумын ЕБС-ийн 1724.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ залруулах бичилт хийж орлого бууруулсан боловч орлогын хуулга хавсрагдаагүй гүйлгээ хийгдсэн.

Амлалтын бүртгэлийн хувьд: Бат-Өлзий, Хужирт сумдын төрийн сангууд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалт хийсэн байгууллагуудад ТТ-4 маягтын хамт батлагдсан төсвөөс нөөц үүсгэн амлалтын бүртгэл хөтөлсөн байна.

Арвайхээр, Уянга, Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Богд, Төгрөг сумдын сургуулийн хоол, үдийн цай, цэцэрлэгүүдийн хоол ЭМТ-ийн шатахуун худалдан авах ажиллагааны тендер зарлагдсан боловч нь амлалтын бүртгэл хөтлөөгүй, Хархорин сумын 1-р сургуулийн хоол, үдийн цай, МГСС-ийн үдийн цай, 2-р сургуулийн үдийн цайнд амлалтын бүртгэл дутуу хөтөлсөн нь МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын журмын 9.1.4 дэх заалт⁴ –ыг зөрчсөн.

Б.1.2. Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага журмын дагуу ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн төрийн сангийн данстын судалгаанаас үзэхэд 704 данс бүртгэлтэй байгаагаас 2017 оны эцэст 61 дансанд 3171656.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч, тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна. Өвөрхангай аймгийн төрийн сан болон харьяа байгууллагуудын арилжааны банк дахь данстын судалгаанаас үзэхэд арилжааны банканд 262 данс бүртгэлтэй байна. 2017 оны эцэст арилжааны банкны

⁴ МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын журмын 9.1.4 дэх заалт “энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан ТТ-4 маягтын хамт Төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ

дүн

42 дансны 189554.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Төрийн сангаас төсвийн байгууллагуудад картын данс нээгдсэн учраас арилжааны банканд гүйлгээ хийхдээ бэлэн мөнгөний хүсэлтээр биш төлбөрийн хүсэлтээр хийдэг болсон байна.

Б.1.3. Төсвийн хэрэгжилтийг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа ч нэмэлт санхүүжилтийн эрхийг журмын дагуу хяналт тавьж олгоогүй байна.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 3.2 дахь заалтын дагуу төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан төсвийн санхүүжилтийн эрхийг дарааллын дагуу олгож байна.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 4.2, 4.3 дахь заалтын дагуу орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилт болон тусгай зориулалтын шилжүүлгийг журамд заасан хугацаанд, батлагдсан төсвийн сар улирлын хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийн тооцоог хийж хугацаанд нь олгож байна.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 4.5 дахь заалтын дагуу санхүүжилтийн эрхийн тооцоог журамд заасан эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж төрийн сангийн тэмдэг дарж баталгаажуулсан байна.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 4.6 дахь заалт байгууллагад олгосон санхүүжилтийн эрхийн тооцоог журамд заасан хугацаанд Төв төрийн санд хүргүүлэн ажиллажээ.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 5.1, 5.2 дахь заалтуудын дагуу зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан зардлын бүлэг болон эдийн засгийн ангиллаар журмын дагуу системд бүртгэн оруулсан.

СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 8.2 дахь заалтын дагуу олгосон санхүүжилт, зарцуулалтын эрхийн холбогдох материалыг архивын нэгж болгон ажилласан байна.

Төсвийн байгууллагуудаас ирүүлсэн төсвийн зохицуулалт хийх хүсэлтийг нэгтгэн Аймгийн Засаг даргын 4 удаагийн А/12, А/246, А/333, А/563 тоот захирамжуудаар төсвийн зарцуулалтын хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн зардлын бүлэг хооронд хийсэн зохицуулалтын хувьд аудитаар илэрсэн зөрчил нь:

Аймгийн болон сумын төрийн санд төсвийн байгууллага зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгээгүй, журмын дагуу харьяа төрийн санд хүргүүлээгүй БСУГ, ЭМГ-т хүсэлтээ холбогдох баримтын хамт ирүүлж байгаа нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан журмын 5 дугаар зүйлийн 5.2-т⁵ заасан заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Арвайхээр сумын цогцолбор сургууль 2468.1 мянган төгрөг, Арвайхээр сумын 2-р цэцэрлэг 6692.6 мянган төгрөг, Арвайхээр сумын 8-р цэцэрлэг 9503.0 мянган төгрөг, Арвайхээр сумын цогцолбор цэцэрлэг 100.0 мянган төгрөг

⁵ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан журмын 5 дугаар зүйлийн 5.2-т "Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгэн, энэ журмын 4-т заасан шаардлагыг хангасан материалын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ"

дүн

- Уянга сумын 2-р сургууль 5000,0 мянган төгрөг , Жаргалант багийн цэцэрлэг 2000.0 мянган төгрөг, Жаргалантын эмнэлэг 2110.0 мянган төгрөг
- Хархорин сумын 1-р сургууль 2000.0 мянган төгрөг, 3-р сургууль 1300.0 мянган төгрөг
- Хужирт сумын сургууль 5000.0 мянган төгрөг, 1-р цэцэрлэг 5500.0 мянган төгрөг, Хужирт сумын эмнэлэг 7000.0 мянган төгрөг
- Бат-Өлзий сумын Соёлын төв 5798.0 мянган төгрөг, Бат-Өлзий сумын ЭМТөв 6014.4 мянган төгрөг
- Нарийнтээл сумын сургууль 1500.0 мянган төгрөг, Баянтээг багийн цэцэрлэг 1735.1 мянган төгрөг, Соёлын төв 200.0 мянган төгрөг, Баянтээг багийн эмнэлэг 963.0 мянган төгрөг, ЭМТөв 3700.0 мянган төгрөгөөр зохицуулалт хийгдсэн боловч ТЗБ№1 маягтаар бэлтгээгүй байна.

Нэмэлт санхүүжилтийн хувьд: Аудитад хамрагдсан аймгийн болон сумдын төрийн сангуудаас Аймгийн төрийн сан, Баянгол, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин сумдын төрийн сангууд нийт 1235537.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрх олгохдоо НТН№1 маягтаар бэлтгүүлдэггүй, бэлтгэсэн ч хянаж баталгаажуулдаггүй, дэмжих баримт болох шийдвэр, орлогын хуулга дутуу хавсаргасан зэрэг нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 7.2 , 7.2.1-4 дэх заалтуудыг⁶ зөрчсөн. Үүнийг сумдаар дэлгэрүүлж үзвэл :

- Аймгийн төрийн санд шууд харьяалагддаг орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудад олгосон нэмэлт санхүүжилтийн материалыг шалгахад 22 төсвийн байгууллагын 920600.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг олгохдоо НТН№1 маягт хөтөлсөн боловч хянасан гарын үсэггүй баталгаажуулаагүй байна.
- Баянгол сумын ЕБС-д 7168.8 мянган төгрөг, СХТөвд 1000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүдийг олгохдоо НТН№1 маягт хөтөлсөн боловч хянасан гарын үсэггүй баталгаажуулаагүй,
- Төгрөг сумын ЗДТГ-т 14346.5 мянган төгрөг, ИТХ-д 2500.0 мянган төгрөг, СХТ-д 1000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүдийг олгохдоо НТН№1 маягт хөтлөөгүй , шийдвэргүй, орлогын хуулгагүй, Санхүүгийн албаны дарга хянаж баталгаажуулаагүй.
- Богд сумын ЗДТГ-т 43453.9 мянган төгрөг, ЕБС-д 2718.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд олгохдоо шийдвэргүй, орлогын хуулгагүй.
- Баруунбаян-Улаан сумын ЗДТГ-т 13863.8 мянган төгрөг, СХТ-д 1000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд олгохдоо НТН№1 маягт хөтлөөгүй , шийдвэргүй, орлогын хуулгагүй, мемериалын баримт болгож үдээгүй.
- Нарийнтээл сумын ЗДТГ-т 15368,7 мянган төгрөг, ИТХ-д 1600.0 мянган төгрөг, 1-р сургуульд 5947.8 мянган төгрөг, СХТ-д 3730.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд олгохдоо НТН№1 маягт хөтлөөгүй , шийдвэргүй, орлогын хуулгагүй, мемериалын баримт болгож үдээгүй.
- Бат-Өлзий сумын ЗДТГ-т 70300.0 мянган төгрөг, Хүн эмнэлэгт 1000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд 2017 онд олгогдсон боловч нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг НТН№1 маягтаар бэлтгээгүй, шийдвэр, хүсэлт хавсаргаагүй.
- Уянга сумын ЗДТГ-т 19908.1 мянган төгрөг, ИТХ-д 1000.0 мянган төгрөг, 1-р сургуульд 6004.0 мянган төгрөг, 2-р сургуульд 6993.5 мянган төгрөг, ЭМТ-д 1000.0 мянган төгрөг, СХТ-д 1000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд 2017 онд олгогдсон боловч нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг НТН№1 маягтаар бэлтгээгүй , шийдвэргүй, орлогын хуулгагүй.

⁶ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 7.2 “ Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээлгэх хүсэлтийг НТН№1 маягтын дагуу бэлтгэн дараах материалын хамт төв болон аймаг нийслэл дүүргийн төрийн санд албан бичгээр ирүүлнэ”

дүн

- Хужирт сумын ЗДТГ-т 46694.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт 2017 онд олгогдсон боловч нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг НТ№1 маягтаар бэлтгээгүй,
- Хархорин сумын ЗДТГ-т 25098.5 мянган төгрөг, Эрдэнэзуу музейд 13545.6 мянган төгрөг, Хархорин музейд 8694.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд 2017 онд олгогдсон боловч нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг НТ№1 маягтаар бэлтгээгүй байна.

Санхүүгийн албаны дарга буюу ерөнхий нягтлан бодогчид нь ажлын байрны чиг үүрэгт заасан нэмэлт санхүүжилтийн эрхийг төсвийн байгууллагад хянан олгох гэсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалж нэмэлт санхүүжилтийн эрхийг илүү дутуу олгох, зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Бат-өлзий, Уянга сумдын төрийн сангууд нэмэлт санхүүжилтийн холбогдох материалыг өдрийн мемориалын баримт болгон архивын нэгж болгон боловсруулж, архивын ажилтанд хүлээлгэн өгөөгүй байгаа нь МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 11.5, 11.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Б.2 ЗГСУМС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна

Б.2.1. Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хүрээг хамарч чадсан.

Системийн функциональ администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байна уу? гэсэн санал асуулгыг 11 сумын төрийн сангаас авахад 8-нь "тийм", 2-нь "зарим талаар", 1-нь "үгүй" гэж хариулт өгснөөс үзэхэд системийн функциональ администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байна гэж дүгнэхээр байна.

Танд зохих эрхийг бүрэн олгосон уу? гэсэн санал асуулгыг 11 төрийн сангаас авахад 9-нь "тийм", 2-нь "зарим талаар" гэсэн хариулт өгсөн нь эрхийг нь бүрэн олгосон байна гэж үзэхээр байна.

Системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон уу? гэсэн санал асуулгад 11 төрийн сан "тийм" гэж хариулт өгсөн нь системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон байна.

Таны эрхийг хязгаарласан тохиолдол бий юу? гэсэн санал асуулгад 9-нь "үгүй", 2-нь "зарим талаар" гэсэн хариулт өгсөн нь эрхийг хязгаарласан тохиолдол байхгүй байна гэж үзэхээр байна.

Системийн функциональ администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу? гэсэн санал асуулгад 11 төрийн сан "тийм" гэж хариулт өгсөн нь системийн функциональ администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна гэж дүгнэхээр байна.

Таны эрхийг давхардуулан ашигладаг хэрэглэгч байгаа юу? гэсэн санал асуулгад 11 төрийн сан "үгүй" гэсэн хариулт өгснөөс үзвэл эрхийг давхардуулан ашигладаг хэрэглэгч байхгүй байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу? гэсэн санал асуулгад 11 төрийн сангийн 8-нь "тийм", 3-нь "зарим талаар" гэж хариулсан байна.

дүн

ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу? гэсэн санал асуулгад 11 төрийн сангийн 7-нь "тийм" гэсэн хариулт өгсөн бол 4-нь "зарим талаар" гэсэн хариулт өгсөн.

ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу? 11 төрийн сангаас авсан санал асуулгыг нэгтгэхэд 4-нь "зарим талаар", 4-нь "тийм", 3-нь "үгүй" гэсэн санал өгсөн байна.

Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу? 6-нь "тийм", 2-нь "зарим талаар", 3-нь "үгүй" гэсэн хариулт өгсөн

Аймаг, сумын төрийн сангийн ажилтнуудын ажлын байранд ашиглаж байгаа компьютерын судалгаанаас үзэхэд суурин 36, зөөврийн 23 компьютер ашиглагдаж байна.

Б.2.2. Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан байна.

ЗГСУМС-д мөрдөх журмын 5.3-т заасны дагуу хэрэглэгчдийн ажил үүргийн ангилал, хэрэглэгчийн эрхийг түр хугацаагаар шилжүүлсэн болон өөрчлөлтийн тайланг улирал болгон Сангийн Яамны төв төрийн санд хүргүүлсэн байна. Сумдын төрийн сангууд Төрийн сангийн мэргэжилтнүүдийг ээлжийн амралттай, түр чөлөөтэй үед ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үгийг түр хугацаагаар эрх түр шилжүүлсэн маягыг хөтөлж баталгаажуулан албан тоотоор аймгийн төрийн санд хүргүүлсэн байна. 1-р улиралд Баянгол, Есөнзүйл, Өлзийт, Хайрхандулаан, 2-р улиралд аймгийн төрийн сан, Богд, Төгрөг, Хархорин сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд, 3-р улиралд аймгийн төрийн сан, Бүрд, Баянгол, Зүүнбаян-Улаан, Богд, Сант, Уянга, Арвайхээр сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд, 4-р улиралд Баянгол, Уянга, Арвайхээр сумдын системийн хэрэглэгчид нэвтрэх нэр, нууц үгийг түр хугацаагаар шилжүүлсэн байна.

2017 оны 1-р улиралд ББ-Улаан сумын Санхүүгийн албаны дарга, 2-р улиралд Баян-Өндөр сумын төрийн сангийн мэргэжилтэн, Зүүнбаян-Улаан сумын Санхүүгийн албаны дарга, Уянга сумын СА-ны дарга, 3-р улиралд Гучин-Ус сумын төрийн сангийн мэргэжилтэн, Уянга сумын СА-ны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, 4-р улиралд Сант сумын төрийн сангийн мэргэжилтэн, Хужирт сумын СА-ны дарга тус тус өөрчлөгдөж Төрийн сангийн мэргэжилтнүүдийг ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үгийг эрх шилжүүлсэн маягыг хөтөлж, албан бичгээр аймгийн төрийн санд ирүүлсэн байна.

Нууцын зэрэглэлтэй төсөвт байгууллага Тагнуул, Зэвсэгт хүчний 256-р анги, 113-р анги, ОБГ зэрэг байгууллагууд байна.

Төрийн нууцын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 09 сарын 11-ны А/429 тоот захирамжаар нууц хариуцсан мэргэжилтэн томилж нууцын баталгаа гаргуулсан байна.

Б.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжээгүй байна.

Б.3.1. Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөгөө өгсөн байна.

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн ЗГСУМС-ийн хэрэглэгчийн ажил үүргийн ангилал, хуваарь, нэгдсэн жагсаалтыг улирал дутам хянаж, хэрэглэгчийн эрхийг түр хугацаанд шилжүүлсэн болон өөрчлөлтийн бүртгэлийг хэлтсийн даргаар хянуулан Төв төрийн санд хүргүүлсэн байна.

дүн

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг үнэлэхэд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Б.3.2. Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт бүрэн хэрэгжээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 8.4-т заасны дагуу дотоод хяналтын тайлан, эрсдэлийн үнэлгээний тайлан, 2017 оны тамга тэмдгийн нэгдсэн бүртгэлийг 2018 оны 01 дүгээр сарын 08-нд Сангийн Яамны төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.


Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4.3-т заасны дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргаар 10 суманд дотоод хяналт хийх төлөвлөгөө батлагдаж Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Арвайхээр зэрэг суманд дотоод хяналт хийсэн байна.

Гүйцэтгэлээр Хужирт, Хархорин сумын Санхүүгийн албаны 2017 оны эхний улирлын төрийн сангийн үйл ажиллагаанд, Бат-өлзий сумын Санхүүгийн албаны 2017 оны эхний хагас жилийн төрийн сангийн үйл ажиллагаанд, Арвайхээр сумын Санхүүгийн албаны 2017 оны эхний 3 улирлын төрийн сангийн үйл ажиллагааг хамруулан аймгийн Засаг даргаар батлуулсан нэгдсэн удирдамжаар дотоод хяналт хийсэн байна.

Шалгалтаар сумдын төрийн сангуудын ажлын ачаалал хэвийн боловч төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх журмуудын хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн албаны ажилтнууд шинэчлэгдсэн, хууль журмын талаар мэдлэг тааруу байгаа нь төсвийн хяналтыг сулруулах гол хүчин зүйл болж байна гэсэн дүгнэлтийг өгч 11 зөвлөмж хүргүүлсэн байна.

Шалгасан сумууд хяналт шалгалтын мөрөөр хийсэн ажлын тайланг ирүүлсэн бөгөөд хяналт хийгдсэн 4 сумдын шалгалтад хамрагдаагүй хугацааны төрийн сангийн үйл ажиллагааг шалгахад төлбөрийн хүсэлтийг стандартын дагуу бичүүлээгүй, амлалтын бүртгэл хөтлөөгүй байгаа нь өгсөн зөвлөмжийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй, зөрчил дахин гарч байна.

Хужирт, Хархорин, Бат-өлзий сумуудын Санхүүгийн алба дотоод хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилган, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай ажлын тайланг хугацаанд нь аймгийн Төрийн санд ирүүлсэн бол Арвайхээр сумын төрийн сангаас тайлан ирүүлээгүй байна.



➤ А.Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна.

• А.1.Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоо зөв оновчтой байна.


- А.1.1. Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон.
- А.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна.

дүн

- **A.2 Төрийн сангийн тогтолцоо бодлого чиг үүрэгтэйгээ нийцэж байна.**
 - A.2.1.Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага байна.
 - A.2.2.Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах зайлшгүй бодит хэрэгцээ шаардлага байхгүй байна.
- **A.3 Төрийн сан хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий болгосон.**
 - A.3.1.Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна.
 - A.3.2.Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давахцаагүй байна.
 - **Б.Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн хангалттай хэрэгжээгүй байна.**
- **Б.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу төдийлөн үр нөлөөтэй гүйцэтгээгүй байна.**
 - Б.1.1. Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, түргэн шуурхай гүйцэтгэж байгаа ч хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, алдаатай хасах залруулгын гүйлгээ, орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу, амлалтын бүртгэл хөтлөөгүй байгаа нь үнэн зөв байдал төдийлөн хангагдахгүй байна.
 - Б.1.2. Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага журмын дагуу хэрэгжиж байна.
 - Б.1.3. Төсвийн хэрэгжилтийг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа ч нэмэлт санхүүжилтийн эрхийг журмын дагуу хяналт тавьж олгоогүй байна.
- **Б.2 ЗГСУМС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна.**
 - Б.2.1. Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан.
 - Б.2.2. Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан.
- **Б.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжээгүй байна.**
 - Б.3.1. Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна.
 - Б.3.2. Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт бүрэн хэрэгжээгүй байна.

ЗӨВЛӨМЖ**СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр, Уянга сумын
Засаг дарга Д.Доржгочоо нарт**

- ✓ Уянга сумын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийг томилж, батлагдсан орон тоогоор ажиллуулах асуудлыг шийдвэрлэх



- ✓ Төсвийн тухай хуулийн 37.1.2, МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.5 дахь заалтыг мөрдөж төсвийн байгууллагын бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн хүсэлтийг хянаж байх
- ✓ Төсвийн тухай хууль 37.1.2, МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8 дахь заалтыг хэрэгжүүлэн төлбөрийн хүсэлтийг үндэслэх анхан шатны болон дэмжих баримыг төрийн сангийн тэмдэглэгээтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах
- ✓ Төсвийн тухай хууль 37.1.2, МУЗГ-ын 2015 оны 24-р тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.2, 8.10 дахь заалтыг мөрдөж ажиллах ажлын 3 хоногт багтаан гүйлгээ хийж байх
- ✓ Төсвийн тухай хууль 37.1.2, МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.12 дугаар заалтыг бүрэн

дүн

хэрэгжүүлж,

САГ-2018-03-СА

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

орлого бууруулсан залруулга хийхдээ орлогын хуулгыг үндэслэн гүйлгээ хийж, мемориалын баримтанд хавсаргаж байх.

- ✓ Төсвийн тухай хууль 37.1.6, МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 9.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж амлалтын бүртгэлийг хөтөлж хяналт тавьж байх.
- ✓ Төсвийн тухай хуулийн 37.1.1, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан журмын 7.2, 7.2.1-4 дэх заалтуудыг мөрдөж нэмэлт санхүүжилтийн эрхийг дэмжих баримтыг үндэслэн хянан олгож байх
- ✓ МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 11.5, 11.8 дахь заалтыг баримтлан нэмэлт санхүүжилтийн материалыг архивын нэгж болгон хүлээлгэн өгч байх

ЗӨВЛӨМЖ

СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр,
Ерөнхий нягтлан бодогч
Б.Баяржаргал

- ✓ СС-ын 2014 оны 65-р тушаалаар батлагдсан журмын дагуу сумдын төрийн сангуудад төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллах.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Төрийн сангийн дотоод
хяналт харууцсан мэргэжилтэн
Э.Энхбаярт

- ✓ Буруу шивсэн, баталгаажаагүй зарлагын гүйлгээг залруулахдаа төлбөрийн хүсэлтийг хавсаргаагүй байна. МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.14 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж буруу шивсэн, баталгаажаагүй зарлагын гүйлгээг залруулахдаа төлбөрийн хүсэлтийг хавсаргаж байх.

ТАЙЛАН БИЧСЭН:


АХЛАХ АУДИТОР *[Signature]* Ж.НЯМАА
АУДИТОР *[Signature]* П.НОРПИЛ
НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]* Р.ЦЭРЭНДОЛГОР

ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Л.ЛАМААЧИН
АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Д.ГАНСҮХ

2018.10.31

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас:7032 2073

2018.10.30 № 20/538
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн сангийн тогтолцоо, 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан болно.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.НЭМЭХБАЯР

012301012

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/

